

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх  
үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 1-ийн 1 “д” заалтыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2012-2016 оны сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн Эдийн засаг, нийгмийн зорилт, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж, хөтөлбөрийн биелэлтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг Засаг дарга /М.Чинболд/-д даалгасугай.

ДАРГА

Х.НЯМБААТАР

Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын ..... оны ... сарын ... -ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Нэг. Дүүргийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг бэхжүүлнэ.

1.1. Бизнес эрхлэгчдийг дэмжих талаар

1.1.1. Зээлийн барьцаа, батлан даалтын хуулийг хэрэгжүүлэхэд дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн үйл ажиллагааг чиглүүлнэ.

1.1.2. Аж ахуйн ур чадвар эзэмшүүлэх сургалт, бизнес инкубаци болон төсөл хөтөлбөр боловсруулах зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээний дэмжлэг үзүүлнэ.

1.1.3. Дүүргийн эдийн засгийн тэргүүлэх 5 чиглэл болох сүү, мах, барилгын материал, сүлжмэл, оёдол, гар урлалын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтыг дээрх салбарт чиглүүлж, дүүргийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгоно.

1.1.4. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллана.

1.1.5. Газар тариалан, төмс, хүнсний ногооны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжиж ажиллана.

1.1.6. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.7. Худалдаа, нийтийн хоол, аялал жуулчлал, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

1.1.8. Толгойт, Баянхошуу, Өнөр бүсүүдэд стандарт шаардлагад нийцсэн хүнсний болон барааны худалдаа, үйлчилгээний цогцолбор төв байгуулах санаачлагыг дэмжинэ.

1.1.9. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.1.10. Архи, тамхины болон эрүүл бус хүнсний хэрэглээг бууруулах бүх нийтийн аян өрнүүлэх замаар эрүүл, соёлтой үйлчилгээ үзүүлдэг бизнесийн байгууллагыг дэмжинэ.

1.1.11. Иргэдэд газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэн өмчилсөн газраа эдийн засгийн эргэлтэнд оруулахад дэмжлэг үзүүлнэ.

1.1.12. Ахуйн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг ойртуулна.

## 1.2. Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын талаар

1.2.1. Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, дүүргийн эдийн засгийн хөгжлийг сайжруулна.

1.2.2. Татварын бааз суурийг нэмэгдүүлэх замаар өөрийгөө тэтгэх эдийн засагтай болох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, цаашдаа төсвөөс авах татаасыг бууруулах чиглэлд бодлогыг уялдуулна.

1.2.3. Төсвийн болон Татварын хууль тогтоомжийг сурталчлах, байгууллага, иргэнийг татварт бүрэн хамруулах, татварын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, өр барагдуулах менежментийг боловсронгуй болгоно.

1.2.4. Аж ахуйн нэгжийн татварын болон санхүүгийн тайлан тушаалт, тендерийн сонгон шалгаруулалт, үр дүн зэрэгт хүний оролцоог багасгаж, 100 хувь цахим тогтолцоог нэвтрүүлнэ.

1.2.5. Орон нутгийг хөгжүүлэх сангийн орлогыг нэмэгдүүлэх менежментийг боловсронгуй болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжинэ.

1.2.6. Дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогыг нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн болон газрын гэсэн ангиллаар явуулж, нийслэлийн өмчийн харилцааны газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүрэн хамруулна.

Хоёр. Ажлын байрыг нэмэгдүүлэн, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ.

### 2.1. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, ядуурлыг бууруулах талаар

2.1.1. Хороодын хөдөлмөрийн цахим биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэн байнгын, түр, цагийн ажлын байраар хангах, зөвлөгөө өгөх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.

2.1.2. Шаардлагатай ажил мэргэжлийн жагсаалтыг хэрэгцээний дарааллаар гарган ажил, мэргэжилгүй иргэдийг мэргэжил олгох болон мэргэшүүлэх давтан сургалтанд хамруулан тэдгээрийн 60-аас доошгүй хувийг байнгын ажлын байраар хангана.

2.1.3. Дүүргийн нутаг дэвсгэрт ажлын байр шинээр бий болгох асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.1.4. Ахмад насны болон нийгмийн эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эхчүүдэд амьдрах орчноо сайжруулах, байгаль орчноо нөхөн сэргээх ногоон ажлын байр бий болгох, хамтарч ажиллах боломжийг бүрдүүлнэ.

2.1.5. Нийгмийн халамжийн үйлчилгээг ядуурлыг бууруулах зорилттой уялдуулж нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн ажилтнуудын ажлын арга барилыг шинэчлэж, нийгмийн халамж шаардлагатай өрх иргэдэд хүрч үйлчилнэ.

2.1.6. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлах, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх талаар ажил зохион байгуулж, тэтгэврийн даатгалыг нөхөн авах иргэдэд мэдээлэл өгч хамруулна.

### 2.2. Эрүүл мэнд, биеийн тамирын чиглэлээр

2.2.1. Эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгож, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж материаллаг баазыг нэмэгдүүлнэ.

2.2.2. Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

2.2.3. Цахим бүртгэлийг хэрэгжүүлэн, хүн амд чирэгдэлгүй, товлот үйлчилгээг нэвтрүүлнэ.

2.2.4. Эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

2.2.5. Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар “Эрүүл мэндийн хөгжил-4” төслийн хүрээнд дүүргийн жишиг эмнэлэг байгуулна.

2.2.6. Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцлийг бүрдүүлэн бие бялдрын чийрэгжүүлэлтийн түвшинг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### 2.3. Боловсролын талаар

2.3.1. Улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлэн хичээллэх ээлжийн тоог бууруулж, анги дүүргэлтийн стандартыг мөрдүүлэх ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.

2.3.2. Улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах асуудлыг шийдвэрлэнэ.

2.3.3. Сургууль, цэцэрлэгт эрүүл аюулгүй, хүртээмжтэй сургалтын орчинг бүрдүүлнэ.

2.3.4. Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэдэх хоолны газрыг өргөтгөж, хүчин чадлыг нэмэгдүүлж, баталгаатай хоол хүнсээр үйлчлэх бүх нөхцлийг бүрдүүлж үдийн цай хөтөлбөрийг чанаржуулна.

2.3.5. ЕБС-уудыг 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлж, бага, дунд боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3.6. Ерөнхий боловсролын сургуулиудыг цахимжуулах, эцэг эх, багш, сурагчдад зориулсан мэдээллийн төвүүд, суралцагчдын амьдрах ухаан, харилцааны ур чадвар, сэтгэн бодох, өөрийгөө илэрхийлэх чадварыг бүрдүүлэх “book safe”-г байгуулна.

2.3.7. Төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

2.3.8. Гэгээрэл хөгжлийн төвийг бие даасан ажлын байртай болгож, Гэгээрэл хөгжлийн төвийн үйл ажиллагааг албан бус боловсролын үйлчилгээнээс иргэн бүрт хүрч үйлчлэх “Насан туршийн боловсролын төв” болгон өргөжүүлнэ.

### 2.4. Соёл, урлагийн чиглэлээр

2.4.1. Иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, хэвшүүлэх ажлыг зохион байгуулна.

2.4.2. Соёл, урлагийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг чанартай хэрэгжүүлнэ.

2.4.3. Дүүргийн соёл, урлагийн наадмыг 2 жил тутам зохион байгуулна

2.4.4. Дүүргийн Соёлын төвийг байгуулж иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### 2.5. Хүүхэд, залуучуудын талаар

2.5.1. Хүүхэд хөгжлийн төв байгуулж үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.

2.5.2. Гэр бүлийн хөгжлийг дэмжих, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

2.5.3. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд болон эмзэг бүлгийн хүүхэд, залуучуудад нийгмийн ажлын үйлчилгээг хүргэнэ.

2.5.4. Хүүхэд, залуучуудыг аливаа эрсдэл, хорт зуршил, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

2.5.5. Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, чадваржуулах ажлыг зохион байгуулна.

Гурав. Иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

### 3.1. Дэд бүтцийн талаар

3.1.1. Дүүргийн нутаг дэвсгэрийн орон сууцны хуучин барилгуудын инженерийн шугам сүлжээг сайжруулна.

3.1.2. Орон сууцны хорооллын байрны дээвэр болон цахилгаан шатыг үе шаттайгаар засварлаж шинэчилнэ.

3.1.3. Замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор авто замуудыг шинээр барих, авто замын өргөтгөл хийх ажлыг зохион байгуулах, зам засварын ажлын чанарыг сайжруулна.

3.1.4. Ард Аюушийн гудамжийг Үйлдвэрчний эвлэлийн гудамжтай холбох 3.1 км замыг гүүрийн хамт барина.

3.1.5. Ашиглалтын шаардлага хангахгүй хуучин орон сууцны барилгуудын газрын эрхийг бүртгэлжүүлж, оршин суугчдын оролцоотойгоор дахин төлөвлөлт хийж барилгажуулах ажлыг концессын гэрээгээр хийж гүйцэтгэнэ.

3.1.6. Иргэдийг хямд үнэтэй орон сууц, амины орон сууцаар хангахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

3.1.7. Гэр хорооллын өрхийн усны хүрэлцээ, хангамжийг сайжруулна.

3.1.8. Гэр хорооллын эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг шинээр холбож, шаардлагатай газруудад хүчдлийг сайжруулна.

3.1.9. Баянхошуу, Орбит, Толгойтод орчимд орчин үеийн дэвшилтэт технологи бүхий дулааны станц, бохир усны гол шугамыг барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.1.10. Гэр хороолол болон шинээр баригдах хороололд ахуйн үйлчилгээний цогцолбор барилга барина.

3.1.11. Иргэдэд үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

3.1.12. Саппорогийн аюулгүй тойрог дээрх олон түвшний огтлолцол барих ажлыг эхлүүлнэ.

3.1.13. Толгойт Сонсголонгийн замын уулзварт барих гүүрэн гарц барих ажлыг эхлүүлнэ.

### 3.2. Тохижилтын талаар

3.2.1. Иргэдийн ая тухтай амьдрах, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх орчныг бүрдүүлэх зорилгоор шаардлагатай газруудад бичил цэцэрлэг, усан оргилуур, тоглоомын талбай, нийтийн бие засах газар, явган хүний зам, гүүр, гарц барина.

3.2.2. Дүүргийн томоохон гудамж, нийтийн эзэмшлийн зам талбайд тохижилт хийнэ.

3.2.3. Авто зам болон нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг, дүүргийн нутаг дэвсгэр дэх рекламны байгууламжийг орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан сайжруулан, орон сууц, гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх замаар асалтыг 95 хувьд хүргэнэ.

3.2.4. Автозам, орон сууцны доторхи зам, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээнд ахиц дэвшил гаргана.

3.2.5. Тусгай зориулалтын зам, шат, хаалга байгуулах ажлыг дэмжиж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээг нэмэгдүүлнэ.

3.2.6. Дүүргийн цэцэрлэгт хүрээлэнг байгуулна.

3.2.7. Тодорхой байршлуудад газар доорх болон давхар граж, авто зогсоол барих чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Дөрөв. Экологи-байгаль орчныг хамгаалахад ахиц дэвшил гаргана.

4.1. Дулааны төвлөрсөн болон бие даасан эх үүсвэрээр хангах боломжгүй гэр хорооллын айл өрхүүдийг эрчим хүчний хэмнэлттэй зуух, боловсруулсан түлш болон утаа шүүгчээр хангаж халаалтын зуухнуудын тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

4.2. Нутаг дэвсгэрийн ойн сан бүхий талбайд нөхөн сэргээлт, арчилгаа цэвэрлэгээ хийнэ.

4.3. Ногоон бүсийн хортон шавьж, өвчний тархалтын судалгаа хийж, хортон шавьж өвчний устгалыг 2000 га талбайд хийнэ.

4.4. Нутаг дэвсгэрийн ногоон бүсийн тодорхой хэсгийг иргэдийн нөхөрлөлд хариуцуулах ажлыг судлан шийдвэрлэнэ.

4.5. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах булаг, шанд, нуурын орчныг тохижуулж, хамгаалалтанд авах, ногоон бүс бүхий уулын амуудад байгаль орчны орон тооны бус байцаагчийн тоог нэмэгдүүлэх

4.6. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран хайрга, шаврын орд ашигладаг иргэн, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд жил бүр үзлэг, шалгалт явуулан, стандартад нийцэхгүй ордуудын үйл ажиллагааг зогсоох, нөхөн сэргээлтийг тусгай төлөвлөгөөний дагуу хийлгэнэ.

4.7. Хөрс, ус, орчны бохирдлыг багасгахад гадаадын төслийн дэмжлэг авч хамтран ажиллана.

4.8. Хог хаягдлыг тээвэрлэх аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, Тээвэрлэлт үйлчилгээний төв, Нийтлэг үйлчилгээний төв, Тохижилт үйлчилгээний компаний материаллаг баазыг нэмэгдүүлэн хур хогийн цэггүй дүүрэг болно.

Тав. Нутгийн захиргааны байгууллагын ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгоно.

5.1. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод байлган, иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэн, нутгийн захиргааны байгууллагын шийдвэрт иргэдийн санал бодлыг тусган хэрэгжүүлж, төрийн боломжит зарим үйлчилгээг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх чиглэл баримтлан ажиллана.

5.2. Шинээр дүүрэг байгуулах асуудлыг боловсруулан саналыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлнэ.

5.3. Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг ажил, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, цахим засаглалыг хөгжүүлнэ.

5.4. Дүүргийн нутгийн захиргааны ордон барина.

5.5. Бүх хороодыг цогцолбор байртай болгоно.

5.6. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх талаар сургалт, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, дээрх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ

5.8. “Архигүй баасан гараг” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.9. Замын хөдөлгөөний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, автын осол, түүнээс учрах хохирлыг бууруулна.

5.10. Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учрах хохирлыг бууруулна.

5.11. Аж ахуйн нэгж, байгууллагад ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн хяналтыг сайжруулах, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлнэ.

5.12. Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт сурталчлах, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж биелэлтэнд хяналт тавин иргэдэд төрийн батлан хамгаалах үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэнэ.

5.13. Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлж, өндөр хөгжилтэй орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтоон, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг татаж ажиллана.

5.14. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ХЭАХН, ШӨХТГ-тай хамтран ажиллана.

Сонгинохайрхан дүүргийн эдийн засаг,  
нийгмийн 2013 оны зорилт батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 1-ийн 2 “а” заалтыг тус тус үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:



1. Сонгинохайрхан дүүргийн эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтыг хавсралт ёсоор баталсугай.
2. Сонгинохайрхан дүүргийн эдийн засаг, нийгмийн 2013 оны зорилтын хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч, байгууллага, иргэдийн бүтээлч идэвхийг өрнүүлэн ажиллаж, биелэлтийн явц, үр дүнг улирал тутам гаргаж Төлөөлөгчдөд мэдээлэх, хагас бүтэн жилээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг Засаг дарга /М.Чинболд/-д даалгасугай.

ДАРГА

Х.НЯМБААТАР

**ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН 2013 ОНЫ ЗОРИЛТ**

Д/д	Үндсэн зорилтын №	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага, хэлтэс, алба
<b>Нэг. Дүүргийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг бэхжүүлнэ.</b>			
<b>Бизнес эрхлэгчдийг дэмжих талаар</b>			
1.	1.1.1	Жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид урт хугацаатай, бага хүүтэй зээл олгоход дэмжлэг үзүүлж холбогдох байгууллагад уламжлах	ХҮХ, ЖДҮДТ
2.		Жижиг дунд үйлдвэрийн зээлд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	ХҮХ, ЖДҮДТ
3.		Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх	СТСХ, ЗХХ
4.	1.1.2	Бичил бизнес болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг сургалтанд хамруулах, холбогдох мэдээ мэдээллээр ханган, инкубатор төвийн бойжигчдын тоог нэмэгдүүлэх	ХҮХ, ЖДҮДТ
5.		Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг бүртгэлжүүлэх	ХҮХ, ЖДҮДТ
6.		21 дүгээр хороонд талх нарийн боовны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй иргэдийг төсөл боловсруулах сургалтанд хамруулан, санал санаачилгыг дэмжин ажиллах	ХҮХ
7.	1.1.3	Жаргалант тосгонд сүү, мах, өндөгний чиглэлийн эрчимжсэн аж ахуй бий болгоход дэмжлэг үзүүлэх	ХҮХ
8.		Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	ХҮХ
9.		Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн эх үүсвэр бий болгоход дэмжлэг үзүүлэх	ХҮХ
10.	1.1.4	Гадаадын хөрөнгө оруулагч нартай хамтран ажиллах боломжийг судлах	ХҮХ, ЗХХ
11.	1.1.5	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд газар олгох, өмнө нь дээрх зориулалтаар олгосон газрын ашиглалтанд дүн шинжилгээ хийх	ХҮХ, ӨГХА
12.		Хүлэмж, Зоорь, Агро парк хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, дүүргийн агро парк түшиглэн ТББ-тай хамтарч сургалт зохион байгуулах	ХҮХ
13.		Тариаланчид, ногоочдын дүүргийн зөвлөгөөн, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	ХҮХ
14.		Аж ахуйн нэгж, иргэдэд бага оврын хүчин чадалтай трактор, дагалдах хэрэгслийг хөнгөлөлттэй үнээр олгуулах боломжийг судлах, тоног төхөөрөмж шаардлагатай байгаа иргэдийн хүсэлтийг холбогдох газруудад уламжлах	ХҮХ

15.	1.1.6	Мал эмнэлэг, хорио цээрийн хяналтыг сайжруулж, Эмээлт дэх “Малын бирж”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах	ХҮХ, МХХ
16.		Дүүргийн мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн үйлчилгээний хамрах хүрээнд /газар нутгийн/ дахин хуваарилалт хийх	ХҮХ
17.		Малын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	ХҮХ
18.		Малчдын зөвлөгөөн зохион байгуулах	ХҮХ
19.	1.1.7	Худалдаа, нийтийн хоолны газруудад цагийн хуваарийг мөрдүүлж, хяналтын системийг боловсронгуй болгон, камержуулах ажлыг эрчимжүүлэх	ХҮХ, ЦХ I, II
20.		Согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй худалдаа, нийтийн хоолны газруудад холбогдох хууль, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг дарга аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг боловсруулан мөрдүүлж ажиллах	ХҮХ
21.		Стандартын шаардлага хангаж буй нийтийн хоолны газруудад тохирлын гэрчилгээ олгуулах	ХҮХ
22.		Худалдаа, нийтийн хоолны газруудыг аттестатчилах хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	ХҮХ, МХХ
23.		Халуун ус, сауны газруудад мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт шалгалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх	ХҮХ, МХХ, ЦХ I, II
24.		26-р хороонд 2 байрилд халуун усны барилгын ажил концессын гэрээгээр гүйцэтгэх жагсаалтанд орсон тул газрын асуудлыг шийдвэрлэх	ӨГХА
25.		Аялал жуулчлалын байгууллагын стандартыг мөрдүүлж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах	ХҮХ, МХХ
26.	1.1.8	Байршлыг тогтоон, газрын үнийг судлах, одоо байгаа үйлчилгээний цэг, салбараа өргөтгөхөөр иргэд ААН-ийн санал санаачлагыг дэмжих	ХҮХ, ӨГХА
27.	1.1.9	Нөөцийн махны борлуулалтын ажлыг зохион байгуулах	ХҮХ
28.		Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний татан авалт, үнийн судалгааг гаргах, аж ахуйн нэгж, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудад “Хүнсний хангамж, аюулгүй байдал” сургалтыг зохион байгуулах	ХҮХ, СХ
29.	1.1.10	Архи, согтууруулах ундааны хууль бус сурталчилгааг таслан зогсоход мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	ХҮХ, МХХ, ЦХ I, II
30.		Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	ХҮХ, ЗХХ, МХХ, ЦХ I, II
31.		Залуучуудад зориулсан “Архигүй” цэнгээний жишиг нийтийн хоолны газрыг дүүрэгт бий болгох	ХҮХ
32.		Худалдаа, үйлчилгээнд даавуун тор, цаасан уутны хэрэглээг нэмэгдүүлэх	ХҮХ
33.	1.1.11	Иргэн бүрт газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлэх	ӨГХА
34.		Хотын ногоон бүсэд зуслангийн зориулалтаар эзэмшиж буй газрыг иргэдэд өмчлүүлэх ажлыг эхлүүлэх	ӨГХА
35.	1.1.12	Монголын үсчин гоо засалчдын холбоотой хамтран мэргэшүүлэх сургалт зохион байгуулах, дүүргийн аварга үсчин, гоо засалч шалгаруулах тэмцээн зохион байгуулах	ХҮХ
<b>1.2. Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын талаар</b>			
36.	1.2.1	Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх	СТСХ, ТХ
37.		Улсын төсвийн болон орон нутгийн байгууллагуудын төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулан оновчтой хуваарилах замаар зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан төсвөөс төлөх өргүй ажиллах чиглэл баримтлах	СТСХ, ТХ
38.	1.2.2	Дүүргийн дэд хөтөлбөр боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулан хэрэгжүүлэх	СТСХ, ТХ, СХ, ЭЗТХ

39.	1.2.3	Татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил төлбөрт тогтоосон актыг барагдуулах, шаардлагатай тохиолдолд энэ талаар олон нийтэд ил тод мэдээлэх ажлыг зохион байгуулах	ТХ
40.		Татварын хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, татварт хамрагдагсдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах	ТХ
41.	1.2.4	Байгууллага, аж ахуйн нэгжийн татварын болон санхүүгийн тайлан гаргах, мэдээлэх ажлыг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	СТСХ, ТХ
42.		Тендерийн зар, баримт бичиг худалдан авах, өгөх, тендерийн үйл ажиллагааны үр дүнг цахим хэлбэрээр харах боломж бүрдүүлнэ.	СТСХ, ХААА
43.		Худалдан авах ажиллагааны албыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх	СТСХ, ААТ
44.	1.2.5	Иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж 2013 онд дүүргийн нутаг дэвсгэрт хийгдэх бүтээн байгуулалт, тохижилт, хөрөнгө оруулалтын ажлын задаргааны төсөл боловсруулан холбогдох газарт уламжлах	ЭЗТХ
45.		Орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын явцад хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг иргэд олон нийтэд мэдээлэх	ЭЗТХ
46.	1.2.6	Дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогыг явуулж, үр дүнг холбогдох байгууллагуудад тавьж, өмчийн менежмент, эрх зүйн орчин бүрдүүлэхэд анхаарах	СТСХ, ӨГХА
<b>Хоёр. Ажлын байрыг нэмэгдүүлэн, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлнэ.</b>			
<b>2.1 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, ядуурлыг бууруулах талаар</b>			
47.	2.1.1	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хороо бүрт цахим бирж ажиллуулах	НХХ, ХХ
48.		Хөдөлмөрийн зах зээлийн шинэчилсэн программ хангамжийг нэвтрүүлж нэгдсэн сүлжээнд холбогдох	НХХ, ХХ
49.		Хөдөлмөрийн хууль тогтоомжийг мөрдүүлэх, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх замаар ажил эрхэлж буй иргэдийг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийн дүүргийн зөвлөлийг байгуулан ажиллах	НХХ, ХХ
50.		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцсэн ажлын байраар хангах, үйлдвэрлэлийн орчныг сайжруулах, хөдөлмөрийн харилцааг зохицуулахад чиглэсэн тогтолцоог бүрдүүлэх	НХХ, ХХ
51.		Нийтийн эзэмшлийн гудамж талбайг тохижуулах, дэд бүтцийг засварлах зэрэг бүтээн байгуулалтанд чиглэгдсэн ажилд нийгмийн эмзэг бүлгийнхэн болон орлогогүй иргэдийг хамруулж түр ажлын байраар хангах	НХХ, ХХ
52.		Ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалтанд оруулж УБ агро-паркад хүнсний ногоо тариулан түр ажлын байраар хангах	НХХ, ХХ
53.	2.1.2	Ажил, мэргэжилгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн болон давтан сургалтанд хамруулж, мэргэжил эзэмшүүлэн 60-аас доошгүй хувийг нь ажлын байраар хангах	ХХ
54.		Аж ахуйн нэгж, байгууллагуудын хэрэгцээнд тулгуурлан ажлын байран дах сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэн ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх	ХХ
55.		Халамж, асрамжийн төвүүдэд хүмүүжсэн залуучуудыг хөдөлмөрт бэлтгэн, ажил мэргэжилтэй болгох	ХХ
56.	2.1.3	Ажлын байр шинээр бий болгох санал, санаачлагыг дэмжиж ажиллах	НХХ, ХХ
57.	2.1.4	Концессын гэрээгээр ахмадын амралт сувиллын газар байгуулах ажлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх	НХХ, НХҮХ, АХ
58.		Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамж, чөлөөт цагийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, чийрэгжүүлэлтийн танхимуудыг 18, 20, 28-р хороодод шинээр байгуулж тохижуулах	НХҮХ
59.		Ахмад настнуудад үзүүлэх төрийн болон халамжийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, рашаан сувилалд	НХҮХ

		хөнгөлөлттэй үнээр амраах ажлыг зохион байгуулах	
60.		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хөгжүүлэх төвийг байгуулах ажлыг эхлүүлэх	НХҮХ
61.	2.1.5	Хороодын амьжиргааг дэмжих зөвлөлийн ажлыг ил тод нээлттэй, нэгдсэн стандарттай болгож, ажлыг нь тогтмолжуулах	НХҮХ
62.		Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэхдээ тэдэнд хөдөлмөрлөж амьдрах чадвар, итгэл үнэмшил бий болгох зорилгоор сургалт зохион байгуулах	НХҮХ
63.		Гэр бүлийн хөгжил, нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэхдээ хувийн хэвшил төрийн бус байгууллагын оролцоо түншлэлийг нэмэгдүүлж, гэрээгээр гүйцэтгүүлэх, үйлчилгээг чанаржуулах	НХҮХ
64.		Нийгмийн халамжийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийг тодорхойлох, мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх асуудлыг орон нутгийнхаа хэмжээнд зохион байгуулах	НХҮХ
65.		Орон нутгийнхаа хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, иргэний бүртгэл зэрэг байгууллагатай хамтран ажиллаж уялдаа холбоогоо сайжруулах	НХҮХ
66.		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх халамжийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	НХҮХ
67.		Ядуурлыг бууруулах, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	НХҮХ
68.	2.1.6	Сайн дурын нийгмийн даатгалд хамрагдагсдын хүрээг өргөтгөх зорилгоор иргэдэд нийгмийн даатгалын талаарх хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах	НДХ
69.		Мал аж ахуй, газар тариалан, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ажилгүй иргэдийг нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх	НДХ
<b>2.2 Эрүүл мэнд, биеийн тамирын чиглэлээр</b>			
70.	2.2.1	ЭМН, салбар амбулаториудын эмчилгээ оношлогооны багаж, тоног төхөөрөмжийг сайжруулах	НХХ, ЭМН
71.		7, 10, 11, 22, 25, 26, 32-р хороодын өрхийн эмнэлгүүдийг дуудлагын унаагаар хангах	НХХ, ЭМН
72.		19-р хороо Нэгдсэн эмнэлгийн хашаанд төрөх газар барих газрын асуудлыг шийдвэрлэх	ӨГХА
73.		Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэн ЭХО, лабораторийн зарим шинжилгээг хийж эхлүүлэх, эмч нарыг сургах	НХХ, ЭМН
74.		Хөнгөвчлөх эмчилгээний үйлчилгээг өргөжүүлэн, хэвтэн эмчлүүлэх ор ажиллуулах	НХХ
75.	2.2.2	Халдварт бус өвчний эрт илрүүлэгийн үзлэгт 30-аас дээш насны эмэгтэйчүүдийг /умайн хүзүүний өмөн, хөхний хавдар/ 3 жил тутамд, 45-аас дээш насны хүмүүсийг артерийн даралт ихсэх болон чихрийн шижингийн хэв шинжийн үзлэгт хамруулах, урьдчилан сэргийлэх ажлыг хүртээмжтэй болгох	НХХ, ЭМН
76.	2.2.3	Амбулаториудад хөтөч ажиллуулан иргэдэд лавлагаа мэдээллийг чирэгдэлгүй хөнгөн шуурхай үзүүлэн лавлагаа, мэдээллийн утас ажиллуулах	ЭМН
77.	2.2.4	Зайн болон ажлын байран дахь сургалтанд эмч, мэргэжилтнүүдийг хамруулах	ЭМН
78.		ЭМТ, өрхийн эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэгийн эмч нарыг мэргэжлийн сургалтуудад хамруулах	ЭМН
79.	2.2.5	Жишиг эмнэлгийн барилгын ажлыг эхлүүлэх	НХХ, НЭ
80.	2.2.6	Спорт цогцолбор болон усан бассейны барилгыг ашиглалтанд оруулж, үйл ажиллагааг жигдрүүлэх	БТСХ
81.		1-р хороо 106-р сургууль, 13-р хороо Ирээдүй цогцолбор сургуулийн 2-р бага сургууль, 18-р хороо 12-р сургуулийн спорт заал барих газрын асуудлыг шийдвэрлэх	ӨГХА
82.		Биеийн тамир спортын тухай хууль, тогтоол шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж бүх нийтийн болон спортын наадам, уралдаан тэмцээн өдөрлөгийг өргөнөөр зохион байгуулах	БТСХ
83.		Хүн амын дунд эрүүл аж төрөх ёсны сургалт сурталчилгааг өрнүүлэх	БТСХ

<b>2.3. Боловсролын талаар</b>			
84.	2.3.1	Тахилтын ам, Баянголын ам, Баруун салаанд ерөнхий боловсролын сургуулийг шинээр ашиглалтанд оруулж, сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлж, ээлжийн тоог бууруулах, 7 дугаар хороонд 920 хүүхдийн суудалтай лаборатори сургуулийн барилгын үйл ажиллагааг эхлүүлэх	НХХ, БХ
85.		104-р сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх	НХХ, БХ
86.		3-р хороо 65-р сургуулийн өргөтгөл, 19-р хороо 62-р сургуулийн өргөтгөл-920, 25-р хороо Зүүн салаанд сургууль-920, 32-р хороо Баруун туруунд сургууль, Эмээлт сургууль-920, 21-р хороо Нарийны ферм бага сургууль, 23-р хороо Хангайн гудамжинд бага сургууль, 28-р хороонд сургууль, 31-р хороо сургууль, 21-р хороо 361-ын гарамд 100 хүүхдийн дотуур байр барих газрын асуудлыг шийдвэрлэх	ӨГХА
87.	2.3.2	4, 7, 8, 20 дугаар хороонд тус бүр 120 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлж, СӨБ-д хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх	НХХ, БХ
88.		25-р хороо 170-р цэцэрлэгийн хашаанд 280 хүүхдийн цэцэрлэг, 32-р хороо Эмээлтэд 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих газрын асуудлыг шийдвэрлэх	ӨГХА
89.		Иргэд, аж ахуйн нэгжүүдээс хүүхэд харах үйлчилгээ, гэр цэцэрлэгийн салбар бүлэг байгуулахыг дэмжих ажлыг зохион байгуулах, хувилбарт сургалтыг нэмэгдүүлэх	НХХ, БХ
90.		26 дугаар цэцэрлэгийн барилгыг актлах асуудлыг шийдвэрлэн, шинээр цэцэрлэгийн барилга барих ажлыг эхлүүлэх	НХХ, БХ
91.		41 дүгээр сувиллын яслийн өргөтгөлийн барилга бариулах асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлах	НХХ, БХ
92.	2.3.3	Сургууль, цэцэрлэгүүдийн гадна талбайг иж бүрэн тохижуулах, цэцэрлэгжүүлэх	НХХ, БХ
93.		Сургууль, цэцэрлэгийн тавилга, тоног төхөөрөмж, эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан тоглоом наадгайг шинэчлэх	НХХ, БХ
94.		Сургууль, цэцэрлэг, орон сууцны хороолол, Үйлдвэрчний эвлэлийн гудамжинд хурд сааруулагч байрлуулах, замын тэмдэг тэмдэглэгээг тавих, замын хөдөлгөөний тэмцээнийг жил бүр тогтмол зохион байгуулах	НХХ, БХ, ЗЦТ
95.		Сургууль, цэцэрлэгийн урсгал болон их засварын ажлуудыг ээлж дараатайгаар үргэлжлүүлэн хийх	НХХ, БХ
96.	2.3.4	Сургууль, цэцэрлэгүүдийн гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, сургууль, цэцэрлэгийн хоолны газрын тогооч нарыг чадваржуулах	НХХ, БХ, ХҮХ
97.		Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэнд мэргэжлийн байгууллага, эцэг, эхийн хяналтыг тогтмолжуулж, эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах	НХХ, БХ, МХХ
98.	2.3.5	Бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэн 12 жилийн тогтолцоонд шилжих үйл ажиллагааг үргэлжлүүлэх	НХХ, БХ
99.	2.3.6	Сургуулиудын интернэт холболт, дотоод сүлжээ ашиглалтыг сайжруулах, компьютерийн тоог нэмэгдүүлэх	НХХ, БХ
100.		Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэд эцэг эх, багш, сурагчдад зориулсан мэдээллийн төв, "book safe" байгуулах ажлыг эхлүүлэх	НХХ, БХ
101.	2.3.7	Төрийн бус өмчийн сургууль цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг дэмжин, багшлах боловсон хүчнийг чанаржуулах ажлыг= зохион байгуулах	НХХ, БХ
102.	2.3.8	Гэгээрэл хөгжлийн төвийн байр барих хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэн, ззэмшил газрыг хашаажуулан хамгаалалтанд авах	НХХ, ГХТ
103.		Насан туршийн боловсролын төв болон өргөжиж байгаатай холбогдон санхүүжилтийг орон нутгийн төсвийн тодотголоор шийдвэрлэх	НХХ, ГХТ
104.		Сургууль завсардалтыг бууруулах ажлыг эрчимжүүлж, шинээр боловсрол нөхөн олгох сургалтын танхимыг хамран сургах тойргийг түшиглэн хичээллүүлэх боломжийг нэмэгдүүлэх	НХХ, ГХТ

<b>2.4. Соёл, урлагийн чиглэлээр</b>			
105.	2.4.1	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хотын түүх, соёлын дурсгалт газруудтай танилцах ажлыг зохион байгуулах	НХХ
106.		Соёлтой өрх, хороо шалгаруулан дүгнэх	НХХ
107.		Иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг бүх нийтийн аян болгох бүтээлч ажлыг зохион байгуулах	НХХ
108.	2.4.2	Монголын уламжлалт урлаг, өв соёлыг сурталчлах өвлүүлэн хөгжүүлэх чиглэлээр Морин хуур Уртын дуу, Бий биелгээ, Монгол Хөөмий, Монгол тууль үндэсний хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	НХХ
109.		Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалт, орчны тохижилтыг сайжруулах, сурталчлах ажлыг зохион байгуулах	НХХ
110.		Соёлын биет болон бус өвийн бүртгэл мэдээллийн санг баяжуулах	НХХ
111.		Нийслэлийн хөөмийчдийн наадам зохион байгуулах	НХХ
112.	2.4.3	“Бид Сонгинохайрханчууд” урлагийн наадам зохион байгуулах	НХХ
113.	2.4.4	Соёлын төвийн ажлыг эхлүүлэх	НХХ
<b>2.5. Хүүхэд, залуучуудын талаар</b>			
114.	2.5.1	Хүүхэд хөгжлийн төвийн байрны асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад уламжлах	НХХ
115.		Хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийг хороодод байгуулж, үйл ажиллагааг идэвхижүүлэх, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх	НХХ, ХГБХТ
116.	2.5.2	Гэр бүлийг дэмжих ажлыг зохион байгуулах	НХХ, ХГБХТ
117.		Хороодын хамтарсан багийг чадавхижуулах сургалт сурталчилгааг зохион байгуулж, хамтарсан багийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах	НХХ, ХГБХТ
118.		Өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох	НХХ
119.		Хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалах байр байгуулах ажлыг төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	ЗХХ, НХХ
120.	2.5.3	Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асруулах, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох ажлыг зохион байгуулж хяналт тавих	НХХ
121.		Хүүхэд хамгаалал, нөлөөллийн төслийг Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	НХХ, ХГБХТ
122.		Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг эрхэлдэг хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх арга хэмжээ авах	НХХ, ХГБХТ
123.		Эмзэг бүлгийн өрхийн хүүхдийг зусланд амраах ажлыг зохион байгуулах	НХХ
124.		Дүүрэгт хүүхдийн халамж асрамжийн төв байгуулах асуудлыг холбогдох байгууллагуудад тавих	НХХ, ХГБХТ
125.	2.5.4	Хүүхэд, залуучуудад хорт зуршил, мансууруулах бодисын хорт нөлөөг таниулах сургалт сурталчилгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	НХХ, ХГБХТ
126.		Цахим тоглоомын газар, интернет төвүүдийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавих, стандартыг мөрдүүлэх	НХХ, ХГБХТ, ЦХ I, II, МХХ
127.	2.5.5	Нийгмийн ажилтнуудыг хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын чиглэлээр сургалтанд хамруулах	НХХ, ХГБХТ
128.		Нийгмийн ажилтнуудын дунд онол практикийн бага хурал зохион байгуулах	НХХ, ХГБХТ
<b>Гурав: Иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.</b>			
<b>3.1. Дэд бүтэц</b>			

129.	3.1.1	Орон сууцны барилгуудын инженерийн гадна, дотор шугам сүлжээг сайжруулах ажлыг үргэлжлүүлэх	ДБТХ
130.		1-р хорооллын 12-р байрны шугам сүлжээг хонгилын системд шилжүүлэх	ДБТХ
131.	3.1.2	Орон сууцны хорооллын байрны дээвэр болон цахилгаан шатыг засварлаж шинэчлэх ажлыг үргэлжлүүлэх	ДБТХ
132.	3.1.3	22-ын товчоо чиглэлийн 10,6 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг үргэлжлүүлэх	ДБТХ
133.		СХД, 25-р хороо, Зүүн салааны 3.6 км авто замыг шинэчилж, шинээр 1.2 км авто зам үргэлжлүүлэн барих	ДБТХ
134.		Баруун салааны 4.1 км авто зам, 18.64+27.68 м гүүрийн барилгын ажлыг үргэлжлүүлэн дуусгах	ДБТХ
135.		Орбит-Тахилтын 7.1 км авто зам, гүүрийн барилгын ажлыг үргэлжлүүлэн дуусгах	ДБТХ
136.		Нийтийн эзэмшлийн болон орон сууц, гэр хорооллын доторх авто зам, гүүрийг шинээр тавих, засварлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	ДБТХ
137.		Хангай зах орчмын 4.8 км үерийн хамгаалалтын байгууламжийн ажлыг үргэлжлүүлэх	ДБТХ
138.		Энхтайваны өргөн чөлөөнөөс МИК руу өгсөх замд ус зайлуулах хоолой шинээр байгуулах асуудлыг судлан холбогдох байгууллагуудад хандах	ДБТХ
139.		Мон-лааны гудамжийг үерийн уснаас хамгаалах, далан барих асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлах	ДБТХ
140.		Махын 1-30 байранд үерийн ус зайлуулах хоолой угсрах асуудлыг судлан холбогдох байгууллагуудад хандах	ДБТХ
141.		Үйлдвэрчний эвлэлийн гудамжны Баянхошуу чиглэлийн 3.4 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлыг дуусгах	ДБТХ
142.		Буяны 2.6 км авто замыг дуусгах /2, 3, 26-р хороо/	ДБТХ
143.		Гэмтлийн эмнэлгийн замаас баруун тийш 1-р хорооллын арын авто замтай холбогдох 1.2 км авто замын ажлыг дуусгах	ДБТХ
144.	3.1.4	Шаардлагатай бэлтгэл ажлыг хангах	ДБТХ, ӨГХА
145.	3.1.5	19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 3-48 айлын байрыг буулгаж, барилгын ажлыг эхлүүлэх	ДБТХ
146.		20-р хорооны Хуучин цэргийн хотхон, Хангамж, 1, 5-р баазын ажилчдын байр, Төмөр замын дан байруудыг “Цэргийн хотхон” орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах ажлыг эхлүүлэх	ДБТХ, ЭЗТХ
147.	3.1.6	Дахин төлөвлөлт хийгдсэн гэр хороололд инженерийн дэд бүтцийг бий болгох чиглэлээр нийслэлийн Захирагчийн албаны дүүрэг дэх албадтай хамтран ажиллах	ДБТХ, ЭЗТХ
148.	3.1.7	2, 7, 9, 21, 22, 23, 24, 25, 26, 28, 30, 31, 32-р хороодод худаг, усан сан барих ажлыг иргэдийн саналыг авч зохион байгуулах	ДБТХ
149.	3.1.8	5, 6, 7, 10, 21, 24, 26, 30, 32-р хороодын эрчим хүчгүй айл өрхийн судалгааг шинэчлэн гаргаж, шинээр холбох, хүчдэл сайжруулах	ДБТХ
150.	3.1.9	Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох эхний ээлжийн байршлуудад оршин суугчдын санал авах ажлыг зохион байгуулах	ДБТХ, ЭЗТХ
151.	3.1.10	Гэр хороололд ахуйн үйлчилгээний цэг салбарын тоог нэмэгдүүлэх	ДБТХ
152.	3.1.11	Тахилт,Толгойт, Баруун салаа, Зүүн салаа, 1-р хорооллын арын дэнжийн чиглэлд үйлчлэх нийтийн тээврийн үйлчилгээний автобусын тоог нэмэгдүүлж, зогсоолыг тохижуулах	ДБТХ
153.	3.1.12	Саппорогийн аюулгүй тойрог дээрх авто замын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэн, замын сүлжээний өргөтгөл хийж, давхар зам шинээр барих ажлыг эхлүүлэх	ДБТХ
154.	3.1.13	Сонсголонгийн авто зам ба гүүрийн өргөтгөл шинэчлэлтийг эхлүүлэх	ДБТХ
<b>3.2. Тохижилт</b>			
155.	3.2.1	8, 9,11, 12, 13, 19, 20, 21, 22, 24, 28, 30-р хороодод иргэдийн саналыг нь авч хүүхдийн тоглоомын талбай байгуулах	ДБТХ



156.		2-р хороонд /42-р сургууль/ хөлбөмбөгийн, 8, 11, 12, 26, 30-р хороодод иргэдийн саналыг авч сагсан бөмбөгийн талбай байгуулах	ДБТХ
157.		8, 12, 18, 20, 28, 29, 30, 31-р хороодод иргэдийн саналыг нь авч бичил цэцэрлэг байгуулж, тохижуулах	ДБТХ
158.		18, 19-р хороодод усан оргилуур бүхий иргэдийн чөлөөт цагийг өнгөрүүлэх талбай байгуулж тохижуулах	ДБТХ
159.		Толгойт, Зүүн салааны автобусны эцсийн буудал, Ханын материал, 1-р хорооллын Саппоро үйлчилгээний төв, 8-р хороо Нуурын орчимд нийтийн бие засах газар байгуулах	ДБТХ
160.		2, 4, 9, 22, 28, 30, 32-р хороодод иргэдийн саналыг авч явган хүний зам барих, засварлах	ДБТХ
161.		2, 24, 26, 28-р хороодод иргэдийн саналыг авч явган хүний гүүр барих	ДБТХ
162.		27 дугаар хорооны Агарын 3 дугаар гудамжийг явган хүний зам, гэрэлтүүлэг бүхий байдлаар тохижуулах	ДБТХ
163.	3.2.2	Энхтайваны өргөн чөлөө, Үйлдвэрчний эвлэлийн гудамжийг иж бүрэн тохижуулах	ДБТХ
164.		Хүй долоон худаг морь барианы газарт үйлчилгээний цэгүүдийн байрлах орчныг тохижуулах	ДБТХ
165.		22-ын товчооны шалган нэвтрүүлэх байрыг ашиглалтанд оруулах	ДБТХ
166.	3.2.3	Авто замын гэрэлтүүлгийн 80 хувийг эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи бүхий LED гэрлээр солих	ДБТХ
167.		Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Нефтийн уулзвараас Орбит хүртэлх, Залуус, Барилгачин гудамжны нийтийн эзэмшлийн зам талбайд 198 ш, 2, 4, 26-р хороодод 340 ш, 6, 13, 14, 16, 20-р хороодын орон сууцны хороололд 82 ш, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3, 5, 8, 9, 10, 11, 18, 21, 22, 23, 25, 26, 28-32-р хороодод иргэдийн саналыг авч гэрэл шинээр тавьж, засвар үйлчилгээг гүйцэтгэх	ДБТХ
168.		Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгжийг орчин үеийн шийдвэр бүхий өнгө үзэмжтэй гэрэлтүүлэгтэй болгох ажлыг зохион байгуулах	ДБТХ
169.		Орон сууцны хороолол, гэр хороолол, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, чимэглэлийн талаар мэдээллийн санг бүрдүүлэн, судалгааг баяжуулах, мэргэжлийн байгууллагын зөвлөгөөгөөр хангах	ДБТХ
170.		Гудамж, талбайд байрлуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн реклам, зар сурталчилгааны самбар, байгууламжид тавих хяналтыг сайжруулж, стандартын шаардлагыг мөрдүүлж ажиллах	ДБТХ
171.	3.2.4	Мэргэжлийн байгууллагын хүн, хүчийг нэмэгдүүлж гол автозам болон орон сууцны хорооллын автозамуудыг арчилгаа, цэвэрлэгэнд бүрэн хамруулах	ДБТХ
172.	3.2.5	Дүүрэгт шинээр баригдаж байгаа болон засварлаж байгаа зам, барилгын ажил, Албан байгууллага, нийтийн үйлчилгээний барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх стандартыг мөрдүүлэх	ДБТХ
173.	3.2.6	Байршлыг тогтоон газрын асуудлыг шийдвэрлэх	ӨГХА, ДБТХ
174.	3.2.7	Иргэдийн санал хүсэлтийг судлан, байршлыг тогтоох	ДБТХ
<b>Дөрөв. Экологи байгаль орчныг хамгаалахад ахиц дэвшил гаргана</b>			
175.	4.1	Эрчим хүчний хэмнэлттэй, ердийн халаалтын зуухыг гэр хорооллын 8000 өрхөд нийлүүлэх	ДБТХ
176.		Байгууллага, иргэд өөрийн хөрөнгөөр утааны шүүлтүүр болон утаа бууруулах зориулалттай тоног төхөөрөмж суурилуулсан тохиолдолд Цэвэр агаарын сангаас зардлыг нөхөж өгөх ажлыг зохион байгуулах	ДБТХ
177.		Агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсийн 300-аас доошгүй айл, өрхийг утаа шүүгчээр хангах	ДБТХ
178.		Агаарын бохирдлыг бууруулах бүсчлэлд хамрагдсан хороодын усан халаалтын зуухтай өрхүүдэд Канадын зуухыг нэвтрүүлэх	ДБТХ
179.	4.2	Нутаг дэвсгэрийн ойн сан бүхий тодорхой талбайг нөхөн сэргээх, ойн арчилгаа цэвэрлэгээ хийх	ДБТХ

180.	4.3	Ногоон бүсийн хортон шавьж, өвчний тархалтын судалгаанд үндэслэн хортон шавьж өвчний устгалыг хийх	ДБТХ
181.	4.4	Ногоон бүсийн тодорхой хэсгийг хамгаалахаар иргэдээс ирүүлсэн санал, санаачлагыг судлан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд асуудал оруулах, хамтран ажиллах	ДБТХ
182.	4.5	8-р хорооны Гүнжийн нуур орчмыг сэргээн засварлах, 22-р хорооны Бөөрийн булгийн орчныг тохижуулж хамгаалалтанд авах	ДБТХ, ӨГХА
183.	4.6	Нөхөн сэргээлтийн ажлыг үргэлжлүүлэн хийж мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллах	ДБТХ, МХХ
184.	4.7	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд айл өрх болон аж ахуйн нэгжүүдийн ашиглаж байгаа гүний худгийн тооллого зохион байгуулах	СХ, ЗХХ
185.		Иргэдийн ундны усны хэрэгцээнд ашиглаж байгаа булаг, шанд гүний худгийн усыг шинжилгээнд хамруулах	ДБТХ, МХХ
186.		Гэр хорооллын хороодын бохирын цооног, 00-ыг ариутгах ажлыг хийх	ДБТХ, МХХ
187.	4.8	Тээвэрлэлт үйлчилгээний төвийн гражийн барилгын санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэн гүйцэтгэж, ашиглалтанд авах	ДБТХ, ТҮТ
188.		Хог тээврийн болон авто зам цэвэрлэгээний тусгай зориулалтын техник, хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	ДБТХ
189.		Гэр хорооллын айл өрхийн хогийг сард 2 удаа хашаанаас нь авах ажлыг хэвшүүлэх	ТҮТ
<b>Тав. Нутгийн захиргааны байгууллагын ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгоно.</b>			
190.	5.1	Дүүрэг, хороодод суурин болон явуулын иргэний танхим байгуулан, тулгамдсан асуудлаар иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулан ажиллах	ЗХХ
191.		Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд иргэд, үйлчлүүлэгчдийн үнэлгээг тогтмол хийлгэж хэвших	ЗХХ
192.		Хороодоос иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг нэг цонхны хэлбэрт шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэх	ЗХХ
193.		10.0 мянгаас дээш хүн амтай 1, 2, 3, 7, 22, 23, 25, 26, 31-р хороодын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, хилийн заагийг шинэчлэх асуудлыг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргэх	ЗХХ
194.		Хороодын хүн ам, өрхийн 2012 оны жилийн эцсийн статистик тоог үндэслэн хэсгийн ахлагчийн тоог шинэчлэн тогтоох	ЗХХ
195.		Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах	ЗХХ
196.	5.2	Хүн амын механик өсөлттэй холбогдон нутгийн захиргааны байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээнд гарч буй хүндрэл, нөхцөл байдлыг судлан тооцоо судалгаа хийх	ЗХХ
197.	5.3	Төрийн үйлчилгээний зарим, боломжит хэсгийг цахим хэлбэрт шилжүүлэх	ЗХХ
